



ЦАХИМ ХӨГЖИЛ, ИННОВАЦ,
ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЯАМ

ДИЖИТАЛ НОМАД ОЛОН УЛСЫН ХӨТӨЛБӨРИЙГ МОНГОЛ УЛСАД ХЭРЭГЖҮҮЛЭХ БОЛОМЖ, НӨЛӨӨЛЛИЙН СУДАЛГАА



УЛААНБААТАР ХОТ
2024 он


АГУУЛГА

1	Дижитал номад хөтөлбөрийг хэрэгжүүлж буй улс орнуудын судалгаа	2
2	Digital Nomad хөтөлбөрийн гол онцлог	2
3	Дижитал номад хөтөлбөрийн зорилго	3
4	Дижитал номад визний онцлох шинж чанар	4
5	Дижитал номад (дижитал нүүдэлчин) виз олгож буй улс орнуудын жагсаалт	6
6	Бүс нутгийн онцлог	8
7	Дижитал номад хөтөлбөрийг хэрэгжүүлснээр бий болох эерэг болон сөрөг нөлөөлөл	9
8	Олон улсын туршлага Дижитал номад хөтөлбөрийг	12
9	Монгол улсад хэрэгжүүлэх боломж эрх зүйн орчин	16
10	Монгол улсын виз Дижитал номад хөтөлбөрийг хэрэгжүүлснээр Монгол	19
11	улсын нийгэм, эдийн засагт нөлөөлөх нөлөөлөл, таамаглал Дижитал номад хөтөлбөрийг	42
12	Монгол улсад хэрэгжүүлэх талаар гаргасан санал, зөвлөмж, дүгнэлт	58



ДИЖИТАЛ НОМАД ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ БҮЙ УЛС ОРНУУДЫН СУДАЛГАА

Дижитал номад (дижитал нүүдэлчин) хөтөлбөр нь гадаад улсад удаан хугацаагаар хууль ёсоор ажиллаж, амьдрах боломжийг олгодог бөгөөд хүчинтэй байх хугацаа нь зургаан сараас нэг жил хүртэл байдаг. Энэхүү хөтөлбөр нь дижитал нүүдэлчдийг алсаас ажиллахад хялбар болгохын тулд визний хөнгөлөлт үзүүлэх зэргээр хууль, эрх зүйн орчныг бүрдүүлж тодорхой хэмжээний дэмжлэгийн үзүүлж тухайн орны амьдралын хэв маяг, соёлыг эдэлдэг. Дижитал номад гэдэг нь өөр өөр газраас онлайнаар ажилладаг, нэг газраас нөгөөд аялахдаа нүүдэлчин амьдралын хэв маягийг баримталдаг хүнийг хэлдэг.



Digital Nomad хөтөлбөрийн гол онцлог:

1. Эрх зүйн орчин: Алсаас ажиллах үедээ тухайн оронд түр оршин суух зөвшөөрөл олгох виз буюу зөвшөөрөл олгоно.
2. Шалгуур: Зайнаас хөдөлмөр эрхэлж буйг нотлох баримт бичиг, орлого нотлох баримт бичиг, зарим тохиолдолд эрүүл мэндийн даатгал орно.



3.Хугацаа: Ихэвчлэн хэдэн сараас хэдэн жил хүртэл үргэлжилдэг бөгөөд сунгах сонголттой байдаг.

4.Татварын бодлого: Татварын үүргийг тодорхой болгож, ихэвчлэн орон нутгийн татвараас чөлөөлөхийг санал болгодог.

5. Дэмжих үйлчилгээ: Хамтран ажиллах оффис, эвент арга хэмжээнд оролцуулах оролцоогоор хангах боломжтой.

Дижитал номад хөтөлбөрийн зорилго

Засгийн газрын хувьд: Эдийн засагт хувь нэмрээ оруулж чадах чадварлаг мэргэжилтнүүдийг татах зорилготой.

Хувь хүмүүсийн хувьд: Зайнаас ажиллахын зэрэгцээ тухайн бүс нутгийн шинэ соёлыг суралцаж, туршлага судлах боломжийг олгох.

Жишээ нь:

- Barbados's Welcome Stamp: Алсаас ажиллагсдад 12 сарын виз олгодог.
- Estonia's Digital Nomad Visa: Дижитал номадуудад Эстони улсад нэг жил хүртэл оршин суух, ажиллах боломжийг олгодог.
- Bali (Indonesia) Second Home Visa: Мэргэжилтнүүд болон тэтгэвэрт гарсан хүмүүст чиглэсэн урт хугацааны алсаас ажиллахыг дэмжсэн виз олгодог.

Эдгээр хөтөлбөрүүд нь уян хатан байдал, шинэ сонирхолтой адал явдал, ажил, аялал, амьдралын тэнцвэрийг хадгалах чадварыг эрэлхийлдэг хүмүүст тохиромжтой байдаг.

2024 оны сүүлийн хагасын байдлаар 66 улс зайнаас ажиллагсдыг татах зорилгоор дижитал номад визийг (DNV) нэвтрүүлээд байна. Тус хөтөлбөрийн онцлог нь улс орон бүрд харилцан адилгүй боловч ерөнхийдөө шинж чанараараа ажлын байрыг нүүлгэхгүйгээр эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэх юм.



Дижитал номад визний онцлох шинж чанар

- Үргэлжлэх хугацаа:

Ойролцоогоор 47% нь нэг жил хүртэл оршин суухыг зөвшөөрдөг дижитал номад виз(DNV) олгодог бөгөөд ихэнх тохиолдолд сунгах боломжтой.

- Татвар:

39 орчим хувь нь дижитал номадуудыг эх орондоо татвараа төлж байгаа гэж үзвэл татвараас чөлөөлдөг.

- Орлогын шаардлагууд:

Зарим улс орнууд орлогын доод шалгуур үзүүлэлтгүй байдаг бол зарим нь өргөдөл гаргагчдаас оршин суух хугацаандаа өөрийгөө тэжээх хэмжээний хангалттай хөрөнгөтэй байх холбогдох нотолгоог шаарддаг.

- Өргөдөл гаргах үйл явц:

Олонх нь буюу 76% орчим хувь нь онлайнаар өргөдлөө өгөхийг санал болгодог бөгөөд дунджаар 80% орчим хувь нь нэг сарын дотор хариу хүргүүлдэг.

Дэлхий даяар байдаг олон арван дижитал нүүдэлчдэд олгодог визэд өргөдөл гаргахдаа өөр өөр шаардлагуудтай байдаг бөгөөд хамгийн чухал нь виз хүсэгчийн жилийн орлого юм.

Global Citizen Solutions компанийн хийсэн судалгаагаар америкчуудад зориулсан хамгийн сайн дижитал номад визний үндсэн 12 үзүүлэлтийг тодорхойлсон байна.

1.өргөдлийн зардал;

2.орлогын шаардлага;

3.визний хугацаа;



- 4.иргэншил хүсэх;
- 5.хугацаа сунгах боломж;
- 6.амьдралын чанар (уур амьсгал, аюулгүй байдал, эрүүл мэнд, бохирдол);
- 7.англи хэлний мэдлэг;
- 8.амьжиргааны өртөг (хүнсний бүтээгдэхүүн, түрээс);
- 9.татвар хөнгөлөлт;
- 10.хамтын оффис;
- 11.интернетийн хурд;
- 12.тус улсын дэлхийн инновацийн индекс.

Дээрх судалгаагаар европийг дижитал нүүдэлчдийн тэргүүлэгч бүс нутаг гэж нэрлэсэн бөгөөд жагсаалтын эхний 10 байрын 9-д нь “Испани, Нидерланд, Норвеги, Эстони зэрэг дэд бүтэц, визний таатай бодлого, иргэншил санал болгодог” улсууд багтаж байна.



**Дижитал номад (дижитал нүүдэлчин) виз олгож буй
улс орнуудын жагсаалт**

1. Арабын Нэгдсэн Эмират, АНЭУ (Дубай, Абу Даби)
2. Албани
3. Ангилья
4. Антигуа ба Барбуда
5. Аргентин
6. Армен
7. Аруба
8. Австрали
9. Багамын арлууд
10. Индонез (Бали)
11. Барбадос
12. Белиз
13. Бермуд
14. Бразил
15. Кабо Верде
16. Кайманы арлууд
17. Колумб
18. Коста Рика
19. Хорват
20. Кюрасао
21. Кипр
22. Чех
23. Доминика
24. Эквадор
25. Египет
26. Эль Сальвадор
27. Эстони



28. Франц
29. Гүрж
30. Герман
31. Энэтхэг (Гоа)
32. Грек
33. Гренада
34. Унгар
35. Исланд
36. Ирланд
37. Итали
38. Япон
39. Латви
40. Малайз
41. Мальта
42. Маврики
43. Мексик
44. Монтенегро
45. Монцеррат
46. Намиби
47. Нидерланд
48. Шинэ Зеланд
49. Хойд Македон
50. Норвеги
51. Панам
52. Перу
53. Португал
54. Пуэрто Рико
55. Румын
56. Гэгээн Люсиа



- 57. Серб
- 58. Сейшелийн арлууд
- 59. Өмнөд Африк
- 60. Өмнөд Солонгос
- 61. Испани
- 62. Шри Ланка
- 63. Тайвань
- 64. Тайланд
- 65. Турк
- 66. Вьетнам

Бүс нутгийн онцлог

- Европ: Испани, Португал, Эстони, Хорват зэрэг улс орнууд дижитал номадуудыг татахын тулд дэд бүтэц, амьдрах таатай орчноо ашиглан дижитал номад виз(DNV)-ийг санал болгож байна.
- Ази: Тайланд, Индонези (Бали), Малайз зэрэг улсууд өөрсдийн таатай уур амьсгал, амьжиргааны өртөг боломжийн бага гэсэн давуу талаа ашиглан дижитал номад виз(DNV)-ийг санал болгож байна.
- Латин Америк ба Карибын тэнгисийн орнууд: Коста Рика, Барбадос, Бразил зэрэг газрууд аялал жуулчлалыг нэмэгдүүлэх, эдийн засгийг идэвхжүүлэх зорилгоор дижитал номад виз(DNV)-ийг санал болгож байна.



ДИГИТАЛ НОМАД ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛСНЭЭР БИЙ БОЛОХ ЭЕРЭГ БОЛОН СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

Дижитал номад (дижитал нүүдэлчин) хөтөлбөрийг хэрэгжүүлснээр дараах эерэг үр нөлөөтэй:

1. Эдийн засгийн үр өгөөж:

Дижитал нүүдэлчид орон байр, хоол хүнс, унаа, чөлөөт цагаа өнгөрөөхөд тодорхой хэмжээний зардал гаргаж тухайн бүс нутгийн эдийн засагт хувь нэмэр оруулдаг. Энэ нь бизнес эрхлэгчдэд тусалдаг. Тухайбал: дижитал нүүдэлчид нь жуулчдаас илүү удаан оршин суудаг нь эдийн засагт илүү тогтвортой орлогын эх үүсвэр бий болгодог.

Эдгээр хөтөлбөрүүд нь урт хугацааны жуулчдыг татах замаар богино хугацааны аялал жуулчлалын хамаарлыг бууруулж, орлогын тогтвортой урсгалыг хангадаг. Мөн аялал жуулчлалыг төрөлжүүлэхэд тусладаг. Тухайлбал: Барбадосын Barbados's Welcome Stamp хөтөлбөр нь тус улсад аялал жуулчлалаас хамааралтай эдийн засгаа төрөлжүүлэхэд тусалсан байна.

2. Дэд бүтцийн хөгжил:

Дижитал нүүдэлчдэд үйлчлэхийн тулд улс орнууд илүү сайн интернетийн холболт, хамтран ажиллах орон зай болон бусад тохилог хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийдэг. Эдгээр сайжруулалт нь дижитал нүүдэлчид болон тухайн нутгийн иргэдэд ашигтай юм. Жишээ нь: Хорват улс дижитал номадуудыг татахын тулд хамтран ажиллах төвүүд болон дижитал дэд бүтэцдээ хөрөнгө оруулалт хийж, илүү сайжруулсан.

3. Соёлын солилцоо ба туршлага солилцох:

Дижитал номадууд ихэвчлэн олон төрлийн ур чадвар, туршлагатай байдаг бөгөөд энэ нь тухайн нутагт инноваци, хамтын ажиллагааг хөгжүүлэхэд тусладаг. Жишээ нь: Бали аралд дижитал нүүдэлчид дижитал маркетинг,



энтрепренёршипийн чиглэлээр семинар зохион байгуулж, орон нутгийн бизнесүүдэд өндөр үр өгөөжийг өгч чадсан байна.

Мөн дижитал нүүдэлчид олон нийтийн мэдээллийн хэрэгслээр туршлагаа хуваалцаж оршин суугаа орныхоо соёлыг шууд бусаар сурталчилдаг.

4.Байгаль орчны эерэг нөлөө:

Богино хугацаанд зорчиж байгаа жуулчидтай харьцуулахад дижитал номадууд илүү удаан оршин тогтнож, нутгийн амьдралын хэв маягтай уялддаг тул байгаль орчны сөрөг нөлөө бага байдаг.

Дижитал номад (дижитал нүүдэлчин) хөтөлбөрийг хэрэгжүүлснээр дараах сөрөг үр нөлөөтэй:

1. Эдийн засгийн тэгш бус байдал: Өндөр орлоготой хүмүүсийн шилжин ирж суурьших нь орон сууцны үнэ болон амьжиргааны өртөгийг өсгөж, улмаар тухайн улс орны үндсэн оршин суугчдад зайлшгүй шаардлагатай үйлчилгээг авахад хүндрэл учруулж болзошгүй. Жишээ нь: Мехико хотод орон сууцны эзэд дижитал нүүдэлчдэд өндөр үнээр түрээслэхийг илүүд үзэж, нутгийн оршин суугчдыг түрээсийн сууцнаасаа нүүлгэн шилжүүлсэн байна. Мөн дижитал номад хөтөлбөрт оролцогчдыг зарим төрлийн татвараас чөлөөлдөг нь уугуул иргэдийн дургүйцлийг төрүүлдэг.

2.Соёлын шилжилт:

Орон нутгийн онцлог өөрчлөгдөх: Дижитал номадуудад үйлчилдэг бизнесүүд нь бусад бизнесүүдийг орлож, иргэдийн соёлын онцлогыг алдагдуулдаг. Жишээ нь: Балигийн Канггу хотод уламжлалт цагаан будааны талбайг кафе, кофе шоп болгон ажлын байраа сольсон байна. Мөн нутгийн иргэд болон дижитал нүүдэлчдийн соёлын ялгаа нь үл ойлголцол, нийгмийн хурцадмал байдалд хүргэж болзошгүй.

3.Дэд бүтцийн ачаалал:



Ит их ачаалалтай нөөц: Хүн амын нягтаршил нэмэгдэж нийтийн тээвэр, нийтийн үйлчилгээний эрэлт нэмэгдэх нь дэд бүтцэд хүндрэл учруулж болзошгүй.

4.Байгаль орчны асуудал:

Хэдий дижитал нүүдэлчид богино хугацааны жуулчидтай харьцуулахад байгаль орчны бохирдол учруулах нь бага ч гэсэн хүн амын тоо, нягтаршил нэмэгдэх нь байгаль орчны доройтолд хүргэж болзошгүй.



ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА

Дижитал номад хөтөлбөрийг хэрэгжүүлэлтээр тэргүүлэгч зарим улс орнуудын эрх зүйн орчин:

1.Испани

Испанийн дижитал нүүдэлчдийн визний мэдүүлгийн үнэ ойролцоогоор 88 доллар байна. Өргөдлийн орчуулгын үйлчилгээ, гадаадын иргэний үнэмлэх (NIE) зэрэг бусад шаардлагатай хураамж одоогоор 11.46 долларын үнэтэй байна. Тус улсын дижитал номад хөтөлбөрийн өөр нэг заалт нь өргөдөл гаргагчид Испанид хүчинтэй байгаа эрүүл мэндийн даатгалын баталгаатай байхыг шаарддаг.

Шаардлагатай доод орлого нь Испанийн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс хоёр дахин их буюу энэ жилийн хувьд сард 2,565 доллар байна. Өргөдөл баталгаажсан дижитал номадуудын оршин суух хугацааг сунгах боломжтой тус улсад нэг жил оршин суух эрх олгодог.

2. Нидерланд

Нидерланд бол АНУ-ын дижитал нүүдэлчдийн хувьд хамгийн сайн сонголтын нэг боловч визээ дижитал нүүдэлчдийн хөтөлбөр гэж нэрлээгүй бөгөөд хувиараа хөдөлмөр эрхлэгч, бие даасан бизнес эрхлэгчээр удаан хугацаагаар оршин суух өөр виз мэдүүлэх боломжтой. MVV гэгддэг энэхүү виз нь гурван жилийн хугацаатай, цаашид сунгах боломжтой. Оршин суух хугацаанаа татвар төлөх ёстой бөгөөд Нидерландын хууль ёсны оршин суугчдын адил орон нутгийн хууль тогтоомжид захирагдана. MVV визэнд хамрагдах нь тухайн хүний хувийн туршлага, бизнес төлөвлөгөө, тухайн улсад төлөх нэмүү өртөг гэсэн гурван үндсэн шалгуураас хамаардаг. Ангилал бүрийг 100 оноогоор үнэлдэг ба нийт 300 оноо авах боломжтой.



3. Норвеги

Норвегийн дижитал номад визний хөтөлбөрт хамрагдахын тулд өргөдөл гаргагчийн паспортын хугацаа тус улсад ирснээс хойш хоёр жилийн хугацаанд хүчинтэй байх ёстой бөгөөд хувиараа хөдөлмөр эрхэлдэг бол тухайн улсаас гадуур бизнес эрхэлдэг гэдгээ нотлох хэрэгтэй болдог. Хэрэв компанитай гэрээ байгуулж байгаа бол ажил эрхэлж буйгаа нотлох баримтаа өгөх ёстой. Бусдаас онцлог нь гэвэл амжилттай өргөдөл гаргагчдаас Норвегийн үйлчлүүлэгчид хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг (цагт ойролцоогоор 17 доллар) төлөх гэрээтэй байх ёстой бөгөөд Европын Аялал жуулчлалын мэдээлэл, зөвшөөрлийн систем (ETIAS)-ийн дагуу бүх өргөдөл гаргагч нь жилд дор хаяж 38,162 долларын цалинтай байх ёстой.) Мөн өргөдөл гаргагч нь оршин суугаа газраа баталгаажуулсан баримт бичигтэй байхаас гадна эрүүл мэндийн даатгалд хамрагдах ёстой. Холбогдох өргөдлийн хураамж нь 641 доллар байдаг.

4. Эстони

Хойд Европт, Балтийн тэнгис, Финландын булантай хиллэдэг Эстони улс дижитал номадуудад оршин суух хугацаанаас нь хамааран хоёр төрлийн виз санал болгодог: Богино хугацааны С виз нь 90 хоногоос доош хугацаагаар оршин суух бөгөөд өргөдөл бүрт 86 долларын төлдөг. Харин урт хугацааны D виз хүсэхэд 108 доллар төлдөг. Шаардлагатай хамгийн бага орлого нь сард 4,846 доллар байх бөгөөд эрүүл мэндийн даатгалд хамрагдах шаардлагатай.

5. Румын

Трансильванийн ой модтой бүсээр алдартай Европын холбооны улс болох Румын улсад дижитал нүүдэлчдийн виз нь нэг жилийн хугацаанд хүчинтэй бөгөөд дараа жил нь сунгах боломжтой. Хүчинтэй паспорт, эрүүл мэндийн даатгал, оршин суух газрын баталгаа, Румын улсаас гадуур зайнаас гүйцэтгэх ажлын баримт, гэмт хэргийн бүртгэлгүй байх, өргөдөл, орлогын доод хэмжээ сард 4000 доллар байх



зэргийг шаарддаг. Өргөдлийг биечлэн, эсвэл тухайн улсын цахим визний вэб сайтад онлайнаар гаргаж болно.

6. Мальта

Сицилийн эргээс холгүй Өмнөд Европт орших Газар дундын тэнгисийн үзэсгэлэнт арлууд болох Мальта бол америкчуудын хоёр дахь иргэншил авахад хамгийн хялбар орнуудын нэг. Мөн дижитал номад визний хөтөлбөртэй бөгөөд өргөдөл гаргагчийг зайнаас ажил гүйцэтгэх боломжтойг нотлох баримт шаарддаг. Тэд гэмт хэргийн бүртгэл, эрүүл мэндийн даатгал, аялалын хүчинтэй баримт бичиг, оршин суух орон байрыг баталгаажуулах ёстой байдаг. Өргөдөл гаргагч нь жилд дор хаяж 45,233 доллар олох ёстой бөгөөд өргөдөл бүр нь 323 доллар, оршин суух үнэмлэхний зардалд 30 доллар байдаг байна.

7. Португал

Португалийн дижитал нүүдэлчдийн виз нь хамгийн алдартай хөтөлбөрүүдийн нэг бөгөөд европын холбооны өртөгийн хувьд боломжийн бизнес эрхлэх орчин сайтай Порто, Лиссабон зэрэг хотуудыг санал болгодог.

Виз хүсэгчийг Португалд нэг жил амьдрахыг зөвшөөрч, дөрөв хүртэлх удаа сунгах боломж олгодог. Өргөдлийн хураамж нь харьцангуй бага буюу \$89, байдаг бөгөөд түүн дээр оршин суух картын хураамж \$78 төлдөг байна. Өргөдөл гаргагчийн сарын орлого хамгийн багадаа \$ 3,511 байх ёстой. Мөн өргөдөл гаргагч нь эрүүл мэндийн даатгалтай, гэмт хэргийн бүртгэлгүй, оршин суух хугацаандаа амьдрах орон байр нь тодорхой байх ёстой.

Саяхан Өмнөд Солонгос, Итали, Япон зэрэг орнууд тус хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлснээр дижитал номад виз(DNV)-ийг санал болгох хандлага хурдацтай явагдаж байна. Кени улс удахгүй дижитал номад виз(DNV)-ийг нэвтрүүлэх төлөвтэй байна.

2021 оны байдлаар дэлхийн хэмжээнд ойролцоогоор 35 сая дижитал номад байсан байна. MBO Partners-ийн гаргасан судалгаагаар зөвхөн АНУ-д гэхэд 2021



онд 15.5 сая дижитал нүүдэлчдийг бүртгэсэн байна. Энэ нь 2019 онд ердөө 7.3 сая байсан бол 112 хувиар өссөн үзүүлэлт юм.

2024 оны сүүлийн байдлаар дэлхийн хэмжээнд дижитал нүүдэлчдийн тоо 80 сая орчим дижитал нүүдэлчинтэй болно гэж тооцоолжээ. Энэ тоонд чөлөөт ажилчид, бизнес эрхлэгчид, аялж байхдаа ажилладаг алсын зайнаас ажилладаг ажилтнууд орно. 18-20 сая америкчуудыг ижитал нүүдэлчид гэж тодорхойлсон нь дэлхийн дижитал нүүдэлчин хүн амын нэлээд хувийг эзэлдэг. ([MBO Partners](<https://www.mbopartners.com>)



ДИЖИТАЛ НОМАД ХӨТӨЛБӨРИЙГ МОНГОЛ УЛСАД ХЭРЭГЖҮҮЛЭХ БОЛОМЖ ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Монгол Улсын нийгэм, эдийн засгийн тогтолцоо өөрчлөгдөн ардчилсан шинэ үндсэн хуулиа 1992 онд баталсны дараагаар бусад хууль, эрх зүйг шинэчлэх ажил үргэлжилсэн. Тухайлбал гадаадын иргэн, харьяалалгүй хүний Монгол Улсад орох, гарах, дамжин өнгөрөх, оршин суух харилцаа болон тэдний эрх үүргийг тогтоосон Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийг 1993 онд анх баталсан байна.

1993 онд батлагдсан дээрх хуулиар Монгол Улсын виз, тус улсад орох, гарах, дамжин өнгөрөх журам, виз олгох байгууллагын эрх, үүрэг үндэслэл, Монгол Улсад орох, орохыг үл зөвшөөрөх үндэслэл, гарах, гарахыг түдгэлзүүлэх тохиолдол, албадан гаргах тухай зохицуулалт болон хууль тогтоомжид зөрчсөн этгээдэд Эрүүгийн хууль болон Захиргааны хариуцлагын тухай хуулиар хариуцлага хүлээгэх ерөнхий заалтыг тусгасан байна.

2010 онд Монгол Улсын Их Хурлаас Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг баталсан бөгөөд уг хууль нь гадаадын иргэдэд оршин суух цахим үнэмлэх олгох асуудлыг шинээр тусгаж, шаардлагагүй зарим зориулалтын буюу “гарах” визийг олгохыг зогсоож, зөрчил гаргасан гадаадын иргэнийг шүүхийн шийдвэрээр түр саатуулах болон түр саатуулах байр орон нутагт ажиллах эрх зүйн орчинг бий болгосон болно. Мөн хуулиар хариуцлагын тогтолцоог тодорхой болгон хууль тогтоомж зөрчсөн этгээдэд оногдуулж байсан захиргааны шийтгэл буюу торгуулийн хэмжээг нэмэгдүүлсэн нь гадаадын иргэн болон тэдгээрийн уригчийг хариуцлагажуулахад тодорхой дэмжлэг үзүүлсэн гэж хэлж болно. ¹Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль 2010 батлагдсан

-
- ¹ Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль, 2020 он



бөгөөд 2020 онд нэмэлт өөрчлөлт орсон. Тус нэмэлт өөрчлөлтөд цахим визны тухай ойлголт орж ирсэн.

“Цахим виз гэж гадаадын иргэнд цахим хэлбэрээр Монгол Улсын виз олгосныг нотлох цахим болон хэвлэмэл баримтыг хэлнэ” гэж тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.15-д заасан байна.

Гадаадын иргэний эрх зүйн байдалтай холбоотой Засгийн газрын тогтоолууд:

- Монгол Улсын виз олгох журам, 2021.07.07, №192;
- Гадаадын иргэн Монгол Улсад оршин суух болон түүнийг бүртгэх журам, 2021.07.07, №194;
- Гадаадын иргэнийг Монгол Улсаас албадан гаргах, албадан гаргахаас чөлөөлөх болон Монгол Улсад дахин оруулахгүй байх хугацааг тогтоох журам, 2021.07.07, №193;
- Монгол Улсын харьяат болох хүсэлт гаргасан гадаадын иргэн, харьяалалгүй хүнд тавих шалгуурыг тогтоох журам, 2003.03.12, №62;
- Агаарын тээврийг хялбаршуулах журам, 2010.11.10, №289;
- Улсын тэмдэгтийн хураамж, визийн үйлчилгээний хөлсний хэмжээг тогтоох тухай, 2021.07.07, №195;
- Улсын тэмдэгтийн хураамж, визийн үйлчилгээний хөлсний хэмжээг тогтоох тухай /тогтоолын хавсралтад нэмэлт өөрчлөлт оруулах тухай/, 2022.12.28, №485.

Гадаадын иргэний эрх зүйн байдалтай холбоотой салбар сайдын тушаалууд:

-
- Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль, 2010 он
 - Гадаадын иргэн монгол улсад оршин суух болон түүнийг бүртгэх журам, Засгийн газрын 2021 оны 194 дүгээр тогтоолын хавсралт



- Гадаадын иргэнд Монгол Улсын харьяат хүүхдийг үрчлүүлэх журам, 2001.04.11, 100/32;
- Барьцаа гаргуулах, буцаан олгох, барьцааны хэмжээг тогтоох журам /ХЗДХС-ын тушаал/, 2011.03.21, 52;
- Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний хяналтын улсын байцаагч тусгай хэрэгсэл, мэх хэрэглэх, тусгай хэрэгслийг хадгалах заавар, 2014.06.09, А/90;
- Гадаадын иргэнд Монгол Улсад оршин суух, харьяалалгүй хүнд зорчих үнэмлэх олгох, хэвлэх болон тэдгээрийг эзэмших, хадгалах, ашиглах журам, 2023.03.31, А/120;
- Олон улсын болон гадаад улсын төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн газарт Монгол Улсад үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл олгох, сунгах, хүчингүй болгох, үйл ажиллагаанд нь хяналт тавих журам, 2022.01.17, А/08.

Эх сурвалж: immigration.gov.mn

² Эх сурвалж: immigration.gov.mn



МОНГОЛ УЛСЫН ВИЗ

Виз гэж Монгол Улсын хилээр нэвтрэх, Монгол Улсад тодорхой хугацаанд байх зөвшөөрлийг хэлнэ. Дараах ангилалын визүүдийг гадаадын иргэнд олгож байна.



МОНГОЛ УЛСЫН ВИЗИЙН АНГИЛАЛУУД

№	Визийн ангилал			Уригчтай эсэх
1	A1	Албан хэргийн зорилгоор	Албан паспорттай бөгөөд албан хэргээр зорчих гадаадын иргэн, Монгол Улсад суугаа гадаад улсын Дипломат төлөөлөгчийн газрын шугамаар ирэх албан болон энгийн паспорттай гадаадын иргэн, цэнхэр өнгийн лесе пасе бүхий Нэгдсэн Үндэстний Байгууллага, түүний төрөлжсөн байгууллагын суурин төлөөлөгчийн газрын ажилтан, албан тушаалтан	Гадаад харилцааны яаманд хандах



2	A1-1	Албан паспорттай бөгөөд албан хэргээр зорчих гадаадын иргэн, Монгол Улсад суугаа гадаад улсын Дипломат төлөөлөгчийн газрын шугамаар ирэх албан болон энгийн паспорттай гадаадын иргэн, цэнхэр өнгийн лесе пасе бүхий Нэгдсэн Үндэстний Байгууллага, түүний төрөлжсөн байгууллагын суурин төлөөлөгчийн газрын ажилтан, албан тушаалтны хамаарал бүхий этгээд	Гадаад харилцааны яаманд хандах
3	A2	Гадаад улсын болон олон улсын хэвлэл, мэдээллийн байгууллагын ажилтан	Гадаад харилцаан яаманд хандах
4	A2-1	Гадаад улсын болон олон улсын хэвлэл, мэдээллийн байгууллагын ажилтны хамаарал бүхий этгээд	Гадаад харилцаан яаманд хандах
5	A3	Засгийн газар хоорондын, төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллага, олон улсын байгууллагын шугамаар ирэх гадаадын иргэн	Уригч байгууллаг мэдүүлнэ
6	A3-1	Засгийн газар хоорондын, төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллага, олон улсын	Уригч байгууллага мэдүүлнэ



			байгууллагын шугамаар ирэх гадаадын иргэний хамаарал бүхий этгээд	
7	B1	Хөрөнгө оруулагч	Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн хөрөнгө оруулагч	Уригч байгууллага мэдүүлнэ
8	B1-1		Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн хөрөнгө оруулагчийн хамаарал бүхий этгээд	Уригч байгууллага мэдүүлнэ
9	B2		Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн хөрөнгө оруулагчийн төлөөлөгч, гүйцэтгэх удирдлагаар томилогдсон гадаадын иргэн	Уригч байгууллага мэдүүлнэ
10	B2-1		Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн хөрөнгө оруулагчийн төлөөлөгч, гүйцэтгэх удирдлагаар томилогдсон гадаадын иргэний хамаарал бүхий этгээд	Уригч байгууллага мэдүүлнэ
11	B3		Гадаадын хуулийн этгээдийн төлөөлөгчийн газрын удирдлагаар ажиллах гадаадын иргэн	Уригч байгууллага мэдүүлнэ
12	B3-1		Гадаадын хуулийн этгээдийн төлөөлөгчийн газрын удирдлагаар ажиллах гадаадын иргэний хамаарал бүхий этгээд	Уригч байгууллага мэдүүлнэ



13	C1	Хөдөлмөр эрхлэгч	Барилга угсралт, зам, гүүр, бүтээн байгуулалтын салбарт ажиллахаар ирэх гадаадын иргэн	Уригч байгууллага мэдүүлнэ
14	C1-1		Барилга угсралт, зам, гүүр, бүтээн байгуулалтын салбарт ажиллахаар ирэх гадаадын иргэний хамаарал бүхий этгээд	Уригч байгууллага мэдүүлнэ
15	C2		Шинжлэх ухаан, боловсрол, мэдээллийн технологийн салбарт ажиллахаар ирэх гадаадын иргэн	Уригч байгууллага мэдүүлнэ
16	C2-1		Шинжлэх ухаан, боловсрол, мэдээллийн технологийн салбарт ажиллахаар ирэх гадаадын иргэний хамаарал бүхий этгээд	Уригч байгууллага мэдүүлнэ
17	C3		Геологи, уул уурхай, газрын тос, эрчим хүчний салбарт ажиллахаар ирэх гадаадын иргэн	Уригч байгууллага мэдүүлнэ
18	C3-1		Геологи, уул уурхай, газрын тос, эрчим хүчний салбарт ажиллахаар ирэх гадаадын иргэний хамаарал бүхий этгээд	Уригч байгууллага мэдүүлнэ
19	C4		Санхүү, эдийн засаг, эрх зүйн салбарт ажиллахаар ирэх гадаадын иргэн	Уригч байгууллага мэдүүлнэ



20	C4-1	Санхүү, эдийн засаг, эрх зүйн салбарт ажиллахаар ирэх гадаадын иргэний хамаарал бүхий этгээд	Уригч байгууллага мэдүүлнэ
21	C5	Соёл урлаг, спортын салбарт ажиллахаар ирэх гадаадын иргэн	Уригч байгууллага мэдүүлнэ
22	C5-1	Соёл урлаг, спортын салбарт ажиллахаар ирэх гадаадын иргэний хамаарал бүхий этгээд	Уригч байгууллага мэдүүлнэ
23	C6	Үйлдвэрлэл, үйлчилгээний салбарт ажиллахаар ирэх гадаадын иргэн	Уригч байгууллага мэдүүлнэ
24	C6-1	Үйлдвэрлэл, үйлчилгээний салбарт ажиллахаар ирэх гадаадын иргэний хамаарал бүхий этгээд	Уригч байгууллага мэдүүлнэ
25	C7	Хөдөө аж ахуй, газар тариалангийн салбарт ажиллахаар ирэх гадаадын иргэн	Уригч байгууллага мэдүүлнэ
26	C7-1	Хөдөө аж ахуй, газар тариалангийн салбарт ажиллахаар ирэх гадаадын иргэний хамаарал бүхий этгээд	Уригч байгууллага мэдүүлнэ
27	C8	Эрүүл мэндийн салбарт ажиллахаар ирэх гадаадын иргэн	Уригч байгууллага мэдүүлнэ



28	C8-1		Эрүүл мэндийн салбарт ажиллахаар ирэх гадаадын иргэний хамаарал бүхий этгээд	Уригч байгууллага мэдүүлнэ
29	C9		Хүмүүнлэгийн салбарт ажиллахаар ирэх гадаадын иргэн	Уригч байгууллага мэдүүлнэ
30	C9-1		Хүмүүнлэгийн салбарт ажиллахаар ирэх гадаадын иргэний хамаарал бүхий этгээд	Уригч байгууллага мэдүүлнэ
31	C10		Өрхийн хэрэгцээнд зориулсан асаргаа, үйлчилгээний чиглэлээр ажиллахаар ирэх гадаадын иргэн	Уригч байгууллага мэдүүлнэ
32	C11		Тээврийн салбарт ажиллах болон экспортын ачаа тээвэрлэх гадаадын иргэн	Уригч байгууллага мэдүүлнэ
33	E1	Суралцах зорилгоор	Ерөнхий боловсролын байгууллагад суралцахаар ирэх гадаадын иргэн	Уригч байгууллага мэдүүлнэ
34	E2		Дээд боловсролын байгууллагад суралцахаар ирэх гадаадын иргэн	Уригч байгууллага мэдүүлнэ
35	E2-1		Дээд боловсролын байгууллагад суралцахаар ирэх гадаадын иргэний хамаарал бүхий этгээд	Уригч байгууллага мэдүүлнэ



36	E3		Монгол хэл, түүх, соёлын болон бусад чиглэлээр мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагад суралцахаар ирэх гадаадын иргэн	Уригч байгууллага мэдүүлнэ
37	E4		Төрийн өмчит хуулийн этгээд болон эрдэм шинжилгээний байгууллагад дадлага, эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийхээр ирэх гадаадын иргэн	Уригч байгууллага мэдүүлнэ
38	E5		Инновацийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх, эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийхээр ирэх гадаадын иргэн	Уригч байгууллага мэдүүлнэ
39	E5-1		Инновацийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх, эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийхээр ирэх гадаадын иргэний хамаарал бүхий этгээд	Уригч байгууллага мэдүүлнэ
40	F1	Гэр бүлийн зорилгоор	Монгол Улсын иргэнтэй гэрлэлтээ бүртгүүлсэн гадаадын иргэн	Уригч иргэн мэдүүлнэ
41	F1-1		Монгол Улсын иргэнтэй гэрлэлтээ бүртгүүлсэн гадаадын иргэний эцэг, эх, өвөг эцэг, эмэг эх, хүүхэд	Уригч иргэн мэдүүлнэ
42	F2		Монгол Улсын харьяатаас гарсан гадаадын иргэн	Уригч иргэн мэдүүлнэ



43	F2-1		Монгол Улсын харьяатаас гарсан гадаадын иргэний хамаарал бүхий этгээд	Уригч иргэн мэдүүлнэ
44	F3		Монгол Улсын иргэнээс төрсөн гадаадын иргэн	Уригч иргэн мэдүүлнэ
45	F3-1		Монгол Улсын иргэнээс төрсөн гадаадын иргэний хамаарал бүхий этгээд	Уригч иргэн мэдүүлнэ
46	G	Цагаачлах	Цагаач	Уригч иргэн мэдүүлнэ
47	G-1	зорилгоор	Цагаачийн хамаарал бүхий этгээд	Уригч иргэн мэдүүлнэ
48	H1	Хувийн	Монгол Улсын төлөө гарамгай гавьяа байгуулсан, эсхүл Монгол Улсад онц шаардлагатай мэргэжил, мэргэшил эзэмшсэн, шинжлэх ухааны аль нэг салбарт онцгой амжилт гаргасан гадаадын иргэн	Уригч иргэн мэдүүлнэ
49	H1-1	зорилгоор	Монгол Улсын төлөө гарамгай гавьяа байгуулсан, эсхүл Монгол Улсад онц шаардлагатай мэргэжил, мэргэшил эзэмшсэн, шинжлэх ухааны аль нэг салбарт онцгой амжилт гаргасан гадаадын иргэний хамаарал бүхий этгээд	Уригч иргэн мэдүүлнэ



50	H2		Монгол Улсын харьяатаас гарахгүйгээр гадаад улсын харьяат болсон иргэн	Уригч иргэн мэдүүлнэ
51	H2-1		Монгол Улсын харьяатаас гарахгүйгээр гадаад улсын харьяат болсон иргэний хамаарал бүхий этгээд	Уригч иргэн мэдүүлнэ
52	H3		Хувийн бусад зорилгоор ирэх гадаадын иргэн	Уригч иргэн мэдүүлнэ
53	J	Шашны зорилгоор	Шашны үйл ажиллагаа эрхлэх зорилгоор ирэх гадаадын иргэн	Уригч байгууллага мэдүүлнэ
54	J-1		Шашны үйл ажиллагаа эрхлэх зорилгоор ирэх гадаадын иргэний хамаарал бүхий этгээд	Уригч байгууллага мэдүүлнэ
55	K1	Түр ирэгч	Ажил хэргийн шугамаар ирэх гадаадын иргэн	Уригч байгууллага мэдүүлнэ
56	K2		Жуулчлах зорилгоор ирэх гадаадын иргэн	Уригчтай болон уригчгүйгээр мэдүүлж болно
57	K3		Хил орчмын жуулчин	Уригчтай болон уригчгүйгээр мэдүүлж болно



58	K4	Соёл урлаг, спортын тэмцээн уралдаан, арга хэмжээнд оролцох, кино, контент бүтээхээр ирэх гадаадын иргэн	Уригчтай болон уригчгүйгээр мэдүүлж болно
59	K5	Импортын ачаа болон зорчигч тээвэрлэх гадаадын иргэн	Уригч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага мэдүүлнэ
60	K6	Дамжин өнгөрөх гадаадын иргэн	Уригчгүй
61	K7	Монгол Улсын олон улсын гэрээгээр тохиролцсоны дагуу харилцан адил нөхцөлөөр хөдөлмөр эрхлэх боломж бүхий богино хугацааны жуулчлалын хөтөлбөрт хамрагдан ирэх гадаадын иргэн	Зөвхөн Австрали улсын иргэдэд хэлэлцээрийн дагуу олгоно
62	K8	Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авахаар ирэх гадаадын иргэн	Уригч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага мэдүүлнэ. /Жич: Хүлээн авагч эмч эмчлэх эрхийн зөвшөөрөлтэй байх/



ВИЗИЙН ХУГАЦАА:

№	Визийн төрөл	Байх хугацаа/Хүчинтэй хугацаа
1	Нэг болон хоёр удаагийн орох, дамжин өнгөрөх виз	90 хүртэл хоног/ 150 хоног
2	Олон удаагийн виз /Түр ирэгчийн/	30 хүртэл хоног/ 183 болон 365 хоног
3	Бүх төрлийн дамжин өнгөрөх виз	10 хүртэл хоног/ 150 хоног
4	Хил орчмын жуулчинд олгох өдрийн виз	3 хүртэл хоног/ 150 хоног

3

Монгол Улсын цахим виз олгох улсын жагсаалт

K2- жуулчин (30 хүртэлх хоног)

K4- соёл урлаг, спортын тэмцээн уралдаан, арга хэмжээнд оролцох, кино, контент бүтээх (30 хүртэлх хоног)

K6- дамжин өнгөрөх (10 хүртэлх хоног)

№	Улсын нэр (Монгол)	Улсын нэр (Англи)
1	Албани	Albania
2	Ангол	Angola
3	Андорра	Andorra

³ Эх сурвалж: immigration.gov.mn



4	Антигуа ба Барбуда	Antigua and Barbuda
5	Армени	Armenia
6	Балба	Nepal
7	Барбадос	Barbados
8	Бахам	Bahamas
9	Белиз	Belize
10	Бенин	Benin
11	Боливи	Bolivia (Plurinational State of)
12	Босни-Херцеговин	Bosnia and Herzegovina
13	Ботсвана	Botswana
14	Бруней Даруссалам	Brunei Darussalam
15	Бурунди	Burundi
16	Бутан	Bhutan
17	Вануату	Vanuatu
18	Ватикан	Vatican City State
19	Венесуэл	Venezuela, Bolivarian Republic of
20	Вьетнам	Vietnam
21	Габон	Gabon
22	Гайана	Guyana
23	Гамби	Gambia (Republic of The)



24	Гана	Ghana
25	Гватемал	Guatemala
26	Гвиней	Guinea
27	Гвиней-Бисау	Guinea Bissau
28	Гренада	Grenada
29	Доминик	Dominica
30	Жибути	Djibouti
31	Замби	Zambia
32	Зимбабве	Zimbabwe
33	Зүүн Тимор	Timor-Leste
34	Кабо-Верде	Cabo Verde
35	Камбож	Cambodia
36	Кени	Kenya
37	Кирибати	Kiribati
38	Колумби	Colombia
39	Коморос	Comoros
40	Конго	Congo
41	Бүгд Найрамдах Ардчилсан Конго	Democratic Republic of the Congo
42	Коста-Рика	Costa Rica
43	Кот д'Ивуар	Côte D'Ivoire



44	Куба	Cuba
45	Кувейт	Kuwait
46	Лесото	Lesotho
47	Маврики	Mauritius
48	Мавритани	Mauritania
49	Мадагаскар	Madagascar
50	Малави	Malawi
51	Маршаллын Арлууд	Marshall Islands
52	Мексик	Mexico
53	Микронез	Micronesia (Federated States of)
54	Мозамбик	Mozambique
55	Молдова	Moldova
56	Монтенегро	Montenegro
57	Мьянмар	Myanmar
58	Намиби	Namibia
59	Науру	Nauru
60	Никарагуа	Nicaragua
61	Өмнөд Африк	South Africa
62	Өмнөд Судан	South Sudan
63	Палау	Palau



64	Панам	Panama
65	Папуа Шинэ Гвиней	Papua New Guinea
66	Руанда	Rwanda
67	Самоа	Samoa
68	Сан Марино	San Marino
69	Сан-Томе ба Принсипи	Sao Tome and Principe
70	Сейшелийн арлууд	Seychelles
71	Саудын Араб	Saudi Arabia
72	Сенегал	Senegal
73	Сент-Винсент ба Гренадин	Saint Vincent and the Grenadines
74	Сент Кристофер ба Невис	Saint Kitts and Nevis
75	Сент Люсия	Saint Lucia
76	Соломоны Арлууд	Solomon Islands
77	Суринам	Suriname
78	Сьерра Леон	Sierra Leone
79	Тайвань	Taiwan (People's Republic of China)
80	Танзани	United Republic of Tanzania
81	Того	Togo



82	Тонга	Tonga
83	Төв Африк	Central African Republic
84	Тринидад ба Тобаго	Trinidad and Tobago
85	Тувалу	Tuvalu
86	Уганда	Uganda
87	Умард Македон	North Macedonia
88	Фижи	Fiji
89	Хаити	Haiti
90	Хондурас	Honduras
91	Хятад	China
92	Экваторын Гвиней	Equatorial Guinea
93	Эль Сальвадор	El Salvador
94	Энэтхэг	India
95	Эритрей	Eritrea
96	Эсватини	Eswatini
97	Этиоп	Ethiopia
98	Ямайка	Пуанда
99	Индонез	Indonesia



Монгол улсын цахим визийг уригчгүй мэдүүлэх (K2, K4, K6, K7):

<https://evisa.mn> цахим хуудсаар цахим визийг уригчгүй мэдүүлж болно.

Визгүй зорчих улсууд:

 Argentina	 Iceland	 Peru
 Australia	 Ireland	 Philippines
 Austria	 Israel	 Poland
 Belarus	 Italy	 Portugal
 Belgium	 Japan	 Romania
 Brazil	 Kazakhstan	 Russian Federation
 Bulgaria	 Kyrgyzstan	 Serbia
 Canada	 Lao People's Democratic Republic	 Singapore
 Chile	 Latvia	 Slovakia
 Croatia	 Liechtenstein	 Slovenia
 Cyprus	 Lithuania	 Spain
 Czech Republic	 Luxembourg	 Sweden
 Denmark	 Macau SAR (China)	 Switzerland
 Ecuador	 Malaysia	 Thailand
 Estonia	 Maldives	 Türkiye
 Finland	 Malta	 Ukraine
 France	 Monaco	 United Kingdom of Great Britain and Northern Ireland
 Germany	 Netherlands	 United States of America
 Greece	 New Zealand	 Uruguay
 Hong Kong SAR (China)	 Norway	 Uzbekistan
 Hungary	 Paraguay	 Vietnam

Түр ирэгч гадаадын иргэний Монгол улсад байх визийн хугацааг сунгах хүсэлт гаргах:

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2, Засгийн газрын 2021 оны 192 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын виз олгох журам”-ын 9.1-т заасны дагуу Монгол Улсад түр ирсэн болон иргэд харилцан зорчих нөхцөлийн талаар байгуулсан Монгол Улсын олон улсын гэрээний дагуу визгүй ирсэн гадаадын иргэний Монгол Улсад байх хугацааг 1 удаа 30 хүртэл хоногоор сунгах боломжтой. Түр ирэгч гадаадын иргэний Монгол Улсад байх

⁴ Эх сурвалж: immigration.gov.mn



хугацаа сунгуулах хүсэлтийг Гадаадын иргэн, харьяатын газарт цахимаар мэдүүлэх боломжтой.

Бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт цахимаар мэдүүлэх бол:

- Сунгалт хийлгэх үндэслэлийг дурьдсан уригчийн албан бичиг (хувь хүн бол өргөдөл)
- Паспортын нүүрэн хэсэг
- Монгол Улсын визтэй хуудас
- Монгол Улсын хилээр нэвтэрсэн штамп дарагдсан хуудас
- Тэмдэгтийг хураамж төлсөн баримт

Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.6.24-т заасны дагуу сунгалтын хоногоос хамаарч доорх тэмдэгтийн хураамжийг төлнө.

Сунгалтын хоног	Хураамж (төг)
1 хоног	40,000
2 хоног	40,000
3 хоног	40,000
4 хоног	40,000
5 хоног	40,000
6 хоног	40,000
7 хоног	40,000
8 хоног	45,600
9 хоног	51,200
10 хоног	56,800
11 хоног	62,400



12 хоног	68,000
13 хоног	73,600
14 хоног	79,200
15 хоног	84,800
16 хоног	90,400
17 хоног	96,000
18 хоног	101,600
19 хоног	107,200
20 хоног	112,800
21 хоног	118,400
22 хоног	124,000
23 хоног	129,600
24 хоног	135,200
25 хоног	140,800
26 хоног	146,400
27 хоног	152,000
28 хоног	157,600
29 хоног	163,200
30 хоног	168,800



visaguide.world дижитал нүүдэлчдийн индексийг танилцуулсан.

Энэ нь Digital Nomad Index буюу дижитал нүүдэлчин байх нь хамгийн тохиромжтой улс орнуудын эрэмбийн систем юм.

Digital Nomad Visa Index нь улс орнуудыг дижитал нүүдэлчдэд тохирсон эсэхээр нь үнэлж, эрэмбэлдэг систем юм. Энэхүү индекс нь өөр өөр улс оронд аялж, амьдардаг алсын зайнаас ажиллагсадын хувьд чухал ач холбогдолтой хүчин зүйлүүдийг авч үздэг.

VisaGuide-аас гаргасан дижитал нүүдэлчдийн индексийн жагсаалтад 38 улс, татвар, татварын хөнгөлөлт эдлэх хугацаа, интернетийн хурд, хамгийн бага орлого, амжиргааны зардал, эрүүл мэндийн үйлчилгээ зэрэг үндсэн 6 үзүүлэлтээр 5 хүртэлх ороогоор эрэмбэлэгдсэн байна.

Жагсаалтын хамгийн эхэнд 4.50 оноогоор Испани орсон бол түүний араас Аргентин 3.72 оноогоор 2-р байрт бичигдсэн байна. Дижитал нүүдэлчдийн шилдэг орнуудын жагсаалтын эхний тавд Румын, Арабын Нэгдсэн Эмират, Хорват улсууд 3, 4, 5 дугаарт эрэмбэлэгдсэн байна.

Дижитал нүүдэлчдийн визний индекс дэх онооны дагуу жагсаасан улс орнуудын дэлгэрэнгүй жагсаалт:

Rank	Country	Taxes	Tax-free period	Internet Speed	Minimum income	Living cost	Health Score	Digital Nomad Score
1st	 Spain	15%	Six months	248.25	2,140	673.7	60.9	4.50
2nd	 Argentina	0%	Full visa length	111.23	2,500	418.5	54.4	3.78
3rd	 Romania	0%	Full visa length	260.97	3,300	539.7	45.7	3.74
4th	 UAE	0%	Full visa length	256.04	5,000	917.0	39.6	3.65
5th	 Croatia	0%	Full visa length	109.27	2,539.31	686.8	48.8	3.62
6th	 Portugal	20%	Six months	205.11	3,548	618.0	54.7	3.58
7th	 Uruguay	0%	Full visa length	177.74	Not required	812.1	40.3	3.55
8th	 Malta	0%	Full visa length	188.55	2,700	781.4	40.2	3.47
9th	 Norway	22%	Six months	186.61	2,977	1,098.9	60.2	3.25
10th	 Andorra	10%	No tax free period	170.11	Not required	736.6	34.7	3.20



Rank	Country	Taxes	Tax-free period	Internet Speed	Minimum income	Living cost	Health Score	Digital Nomad Score
11th	 Aruba	0%	Full visa length	89.81	5,000	1,078.6	52.9	3.18
12th	 Montenegro	11%	No tax free period	87.87	Not required	586.0	44.1	3.18
13th	 Costa Rica	10% to 20%	Six months	91.08	3,000	753.0	40.8	3.16
14th	 Mexico	30%	No tax free period	77.07	2,595	587.2	57	3.15
15th	 Curacao	0%	Full visa length	58.12	Not required	1,004.0	45.3	3.15
16th	 Panama	0%	Full visa length	168.86	3,000	698.2	53.5	3.13
17th	 Czechia	23%	No tax free period	112.81	2,500	756.2	52.8	3.11
18th	 Hungary	15%	Six months	245.97	2,000	627.3	54.4	3.11
19th	 Sri Lanka	0%	Full visa length	32.54	2,000	404.3	34.1	3.05
20th	 Estonia	20%	No tax free period	103.48	3,500	795.5	55.5	3.01

5

Rank	Country	Taxes	Tax-free period	Internet Speed	Minimum income	Living cost	Health Score	Digital Nomad Score
21st	 South Africa	18%	No tax free period	70.79	3,000	505.7	45.8	2.98
22nd	 Cabo Verde	0%	Full visa length	17.84	1,500	606.0	34.1	2.90
23rd	 Barbados	12.5% to 28.5%	1 year	123.62	4,166	1,095.3	34.9	2.89
24th	 Georgia	20%	Six months	30.28	2,000	566.5	52.6	2.89
25th	 Dominica	15% to 35%	No tax free period	135.36	4,166	800	26.4	2.88
26th	 Montserrat	0%	Full visa length	60	5,833	940	43.33	2.88
27th	 Seychelles	0%	Full visa length	48.8	Not required	860.0	31.8	2.88
28th	 Greece	20%	Six months, 10% if staying 2 years	56.43	3,500	748.0	51.5	2.84
29th	 Bermuda	0%	Full visa length	74.21	Not required	1,907	47.04	2.77
30th	 Bahamas	0%	Full visa length	71.88	Not required	1,308.7	30.1	2.73

Rank	Country	Taxes	Tax-free period	Internet Speed	Minimum income	Living cost	Health Score	Digital Nomad Score
31st	 Ecuador	35%	No tax free period	66.78	1,350	489.0	50.8	2.68
32nd	 Brazil	17% to 20%	Six months	172.2	1,500	523.0	51.2	2.67
33rd	 Colombia	19%	Six months	125.86	684	439.2	53.2	2.61
34th	 Antigua and Barbuda	0%	Full visa length	35.05	4,166	1030	30	2.52
35th	 Cayman Islands	0%	Full visa length	16.12	8,333	1,638.9	47.04	2.36
36th	 Iceland	0%	Full visa length	229.35	7,000	1,181.3	48.5	2.18
37th	 Cyprus	20% to 35%	Six months	80.97	3,500	831.4	41.9	1.89
38th	 Anguilla	0%	Full visa length	75.38	Not required	4200	45.3	1.54

⁵ <https://visaguide.world/digital-nomad-visa/digital-nomad-index/>



Дэлхий нийтийг хамарсан шилжилт хөдөлгөөний их урсгалд нийцүүлэн улс орон бүр баримталж буй бодлогоо өөрчлөх, техник технологийн ололтыг ашиглах замаар гадаадын иргэдэд виз, оршин суух, бүртгэлийн талаарх тааламжтай нөхцөлийг бүрдүүлэхийн зэрэгцээ нөгөө талаас улс орны дотоодын аюулгүй байдлыг хамгаалах гэсэн хоёр ойлголтын уулзварыг тэнцвэртэй хангахыг зорьж байна.

Үндсэн зорилго нь тухайн улс оронд шаардлагатай, хүсэл зорилгоо илэрхийлсэн гадаадын иргэд дундаас сонголт хийн зохих визийг олгон, өөрийн орны иргэдэд ногдох түр болон удаан хугацаагаар оршин суугч гадаадын иргэдийн зөв, зохистой харьцааг тогтоох замаар эдийн засаг, нийгмийн өсөлтийг бий болгох явдал юм.

Дижитал номад хөтөлбөрийн хувьд Монгол улсад албан ёсоор хэрэгжээгүй бөгөөд эрх зүйн орчин хараахан бүрдээгүй байна. Тиймээс гадаадын иргэд Монгол улсын визийн ангилалын дагуу тохирох ангилалын визээ мэдүүлж Монгол улсад зорчиж байна.⁶

⁶ Эх сурвалж: immigration.gov.mn



ДИГИТАЛ НОМАД ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛСНЭЭР МОНГОЛ УЛСЫН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСАГТ НӨЛӨӨЛӨХ НӨЛӨӨЛӨЛ, ТААМАГЛАЛ

“Дижитал номад хөтөлбөр” хэрэгжсэнээр эдийн засаг, соёл, технологи, аялал жуулчлал, нийгмийн хөгжил зэрэг олон салбарт олон эерэг нөлөө үзүүлэх боломжтой.

1. Эдийн засгийн өсөлтийн таамаглал:

Гадаадын хөрөнгө оруулалт нэмэгдэнэ: Дижитал нүүдэлчдийг татах нь гадаадын хөрөнгө оруулалтыг Монголд оруулж ирэх боломжийг нэмэгдүүлнэ. Учир нь тэд байр, хоол, унаа болон үйлчилгээнд мөнгө зарцуулах болно. Гадаадаас орж ирэх энэхүү орлогын урсгал нь ялангуяа Улаанбаатар болон томоохон аймгуудын эдийн засгийг идэвхжүүлж, алсаас ажилчсадад тохирсон дэд бүтэц, үйлчилгээг хөгжүүлэхэд хувь нэмэр оруулах боломжтой.

Ажлын байр бий болно: Дижитал номад хөтөлбөр нь зочлох үйлчилгээ, үл хөдлөх хөрөнгө, аялал жуулчлал зэрэг дижитал нүүдэлчдийн хэрэгцээг хангах салбар бүрт шинэ ажлын байр бий болгох боломжтой. Энэ нь нүүдэлчдийн хэрэгцээнд нийцсэн өндөр хурдны интернет үйлчилгээ үзүүлэгч, кафе, кофе шоп, ресторан, зочид буудал, үл хөдлөх хөрөнгө түрээс зэрэг үйлчилгээний өсөлтөд түлхэц болно.

Эдийн засгийг төрөлжүүлнэ: Монгол Улсын эдийн засаг уул уурхай, хөдөө аж ахуй, мал аж ахуйд төвлөрдөг. Дижитал нүүдэлчдийг татснаар Монгол улс эдийн засгаа төрөлжүүлж, илүү тэсвэртэй эдийн засгийг бий болгох боломжтой. Энэ нь Монгол улсыг уул уурхайгаас хараат байдлыг бууруулж, эдийн засгийн тогтвортой байдлыг бий болгоход тодорхой хэмжээнд нөлөөлнө.



2. Соёлын солилцоо:

Олон улсын хамтын ажиллагаа хөгжинө: Дижитал нүүдэлчид янз бүрийн улс орон, соёл иргэншлийг сурталчлах бөгөөд Монголд амьдрах хугацаандаа улс хоорондын соёлын солилцоог нэмэгдүүлэх боломж бүрдэнэ. Энэ нь бизнес, технологи, урлагийн салбарт хамтын ажиллагааг өргөжүүлж, Монгол өв, соёлыг дэлхийн хэмжээнд түгээн дэлгэрүүлэхийн зэрэгцээ төрөл бүрийн санаа, мэдлэгийг эх орондоо авчрахад түлхэц болох юм.

Монголын өв, соёлыг сурталчлах: Дижитал нүүдэлчид иргэдтэй харилцаж, туршлагаа хуваалцаж, аялал жуулчлал, соёлын мэдлэгийг сурталчлаад зогсохгүй Монголын соёлын элч нар болох магадлалтай. Мөн манай улсын өвөрмөц уламжлал, түүх, өв соёлоос суралцаж, дэлхийн соёлыг Монгол улсад түгээх боломж бүрдэнэ.

Соёлын арга хэмжээ, сүлжээ: Дижитал нүүдэлчид ихэвчлэн уулзалт, семинар, эвент арга хэмжээ зохион байгуулдаг. Эдгээр үйл ажиллагаа нь монголчууд төдийгүй дижитал нүүдэлчид өөрсдийн соёлоо сурталчлах, соёлоо солилцох, хуваалцах талбар болж, соёлын солилцооны идэвхтэй экосистемийг бий болгоно.

3. Технологийн мэргэжилтнүүдийн суралцах боломж:

Мэдлэгээ хуваалцах: Технологийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй хүмүүс, технологийн мэргэжилтнүүдэд хамтран ажиллах, зөвлөн туслах, мэдлэгээ хуваалцах шинэ боломжийг олгоно. Монголын технологийн мэргэжилтнүүд олон улсын дижитал нүүдэлчидтэй хамтран технологитой холбоотой янз бүрийн төсөл, гарааны бизнест хамтран ажиллах замаар ур чадвараа дээшлүүлэх боломжтой.

Технологийн гарааны бизнес ба инновац: Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр дижитал нүүдэлчид, бизнес эрхлэгчид, хөрөнгө оруулагчдыг нэгтгэх замаар технологийн гарааны бизнесийг бий болгоход түлхэц болно. Монголын



технологийн мэргэжилтнүүд шинэ төсөл дээр хамтран ажиллах, шинэ дижитал бүтээгдэхүүн хөгжүүлэх, венчур хөрөнгө татах боломжтой.

4. Аялал жуулчлалын хөгжил эрчимжих боломж:

Эко-аялал жуулчлал ба тогтвортой аялал: Дижитал нүүдэлчид ихэвчлэн тогтвортой амьдралыг дэмждэг газар руу татагддаг. Байгалийн үзэсгэлэнт газар нутаг, байгалийн унаган төрхтэй Монгол Улс дижитал нүүдэлчдэд чиглэсэн эко аялал жуулчлалын багцыг сурталчлах замаар аялал жуулчлалыг илүү хөгжүүлэх боломжтой.

Урт хугацааны аялал жуулчлал: Богино хугацаагаар аялдаг уламжлалт жуулчдаас ялгаатай нь дижитал нүүдэлчид удаан хугацаагаар оршин суух хандлагатай байдаг. Энэ нь урт хугацааны аялал жуулчлалыг нэмэгдүүлж, бизнес эрхлэгчид болон аялал жуулчлалын операторуудад тогтвортой орлогын урсгалыг бий болгох боломжтой.

Дэд бүтэц: Коворкинг, хамтын оффис, алсын зайн ажлын төв, дижитал нүүдэлчдэд ээлтэй орон сууцнуудад хөрөнгө оруулах боломжтой. Эдгээрийг аялал жуулчлалын томоохон газруудын ойролцоо байгуулж, дижитал нүүдэлчдийн ажил, амралт чөлөөт цагийг тэнцвэржүүлэх боломжтой.

5. Нийгмийн салбарын нөлөө:

Ур чадварыг нэмэгдүүлэх: Дижитал нүүдэлчид ихэвчлэн програм хангамж боловсруулах, маркетинг, дизайн, бизнес эрхлэх зэрэг салбарт үнэ цэнэтэй мэдлэгийг түгээдэг.

УЛСЫН ХИЛЭЭР ОРСОН ЖУУЛЧДЫН ТОО (улсаар, жилээр)

Улсын нэр	2017	2018	2019	2020	2021	2022	2023
БҮГД	469309	529370	577300	58859	33100	286282	594013
Афганистан	23	38	33	0	0	7	33
Албани	18	12	44	1	2	11	38
Антарктид				0	0		0



Алжир	5	12	8	0	1	4	13
Америкийн Самоа				0	0		0
Андорра	7	2	10	0	0		4
Ангол	1		5	0	0		6
Антигуа Барбуда		1	1	0	0	0	3
Азербайджан	74	177	143	43	96	296	467
Аргентин	559	586	438	10	5	40	104
Австрали	7287	7495	7014	383	132	1340	3437
Австри	1579	1349	1533	57	81	464	840
Бахам	1	1		0	0		0
Бахрейн	44	28	18	0	0	4	14
Бангладеш	171	170	189	7	38	83	134
Армен	69	67	47	6	7	18	38
Барбадос	1	1	2	0	0		1
Бельги	1532	1505	1436	30	33	476	796
Бермудын Арал				0	0		0
Бутан	58	60	64	0	0	15	32
Боливи	19	19	24	3	2	12	23
Босни Герцеговини	16	16	14	0	0	8	18
Ботсван	2		1	0	0	1	4
Буве арал				0	0		0
Бразил	719	758	872	24	16	176	269
Белиз	3	5	6	1	0		0
Британийн Энэтхэгийн Далай Дахь Нутаг Дэвсгэр				0	0		0
Соломоны Арлууд	1	10	6	1	1	1	2
Виржиний Арлууд (Британи)				0	0		0
Бруней	10	9	38	0	0	3	10
Болгар	172	177	174	8	11	70	142
Мьянмар	104	86	143	3	20	11	79
Бурунди	3	4	13	5	3		1
Беларус	2107	2210	2902	2090	4026	4029	6902
Камбож	115	142	137	5	0	119	100



Камерун	8	9	6	0	0	6	16
Канад	3430	3578	3594	169	123	1103	1952
Кабо Верде	2	2	2	0	0	2	0
Кайманын Арлууд				0	0		0
Төв Африк	1	2	2	0	0		2
Шри Ланк	94	142	176	7	5	58	72
Чад	0			0	0		2
Чили	153	216	193	3	6	40	75
Хятад	142481	163979	168298	13513	5763	11186	108869
Хятад, Тайван	4452	5233	5930	95	30	317	5129
Зул Сарын Арал				0	0		0
Кокосын Арлууд				0	0		0
Колумби	98	93	154	12	5	40	81
Коморос	2	2		0	0	1	0
Маёtti				0	0		0
Конго	21	24	14	3	0	7	7
Ардчилсан Конго				0	0		0
Кукын Арлууд				0	0		0
Коста Рика	20	53	140	0	0	7	26
Хорват	63	102	84	6	3	29	85
Куба	83	58	49	3	5	17	26
Кипр	19	33	47	0	0	12	15
Чех	1036	1116	1068	50	100	347	679
Бенин	2	3	7	1	0	3	1
Дани	527	568	615	40	18	143	285
Доминика		8	6	1	0	2	4
Доминикан		7	6	0	0	2	5
Эквадор	21	19	27	0	1	11	28
Салвадор	5	5	17	0	1		6



Эквадорын Гвиней	1			0	0		0
Этиоп	50	66	57	73	47	75	24
Эритри			2	0	0		0
Эстони	104	75	131	10	2	20	87
Фарер Арлууд				0	0		0
Мальвиний				0	0		0
Өмнөд Жорж ба Сендвичийн Арлууд				0	0		0
Фижи	22	13	68	0	7	13	26
Финланд	668	535	682	19	11	92	266
Аландын арлууд				0	0		0
Франц	10038	9773	10572	305	213	2863	5677
Францын Гвиана				0	0		0
Францын Полинез				0	0		0
Францын Өмнөд Нутаг Дэвсгэр				0	0		0
Жибути	1	2	1	0	0		0
Габон				0	0		0
Гүрж	31	37	64	19	76	80	86
Гамби				0	0		0
Палестин	7	9	15	0	0	39	11
Герман	10582	10819	12405	599	511	3994	9275
Гана	19	19	15	4	2	9	35
Гибралтар				0	0		0
Кирибати	1	3	3	0	0		6
Грек	174	266	312	7	15	118	207
Гренланд				0	0		0
Гренада	1	2	6	5	0	0	4
Гваделупа				0	0		0
Гуам				0	0		0
Гватемал	5	6	9	0	0	4	6



Гвинея	1	1	3	0	1	1	4
Гайана		1		0	0		3
Гаити	1		1	0	0		6
Херд ба Макдональдын Арлууд				0	0		0
Ватикан	3	3	4	0	1	3	51
Гондурас	3	11	4	1	0	2	1
Хятад, Хонконг	2808	3121	4311	147	8	244	2622
Унгар	439	401	503	13	76	249	400
Исланд	41	46	32	3	2	34	56
Энэтхэг	1874	2298	2478	184	194	1041	1929
Индонез	466	627	553	25	13	173	503
Иран	172	227	302	18	62	221	309
Ирак	32	58	52	0	43	46	67
Ирланд	534	563	474	29	16	145	301
Израиль	902	939	1152	16	21	328	646
Итали	2971	3192	3655	74	174	1007	2488
Ямайка	11	4	11	0	2		5
Япон	22519	20990	24419	1131	377	6411	19600
Казакстан	14234	16144	16264	1509	727	17555	20537
Йордан	36	54	86	1	13	27	71
Кени	34	27	27	6	3	17	41
Солонгос /Өмнөд/	74921	84184	101279	5060	2312	53382	139512
Кувейт	121	136	162	7	31	54	127
Киргиз	415	524	727	57	107	774	1515
Лаос	71	153	104	5	65	61	170
Ливан	22	36	51	3	6	20	29
Лесото	1		2	0	0	4	4
Латви	100	118	109	12	10	39	73
Либеря	1		2	0	0	1	0
Ливийн Жамахири		4	2	0	0	1	19
Лихтенштейн	18	10	9	0	0	2	6
Литва	119	113	125	2	4	68	154
Люксембург	70	66	99	0	2	43	86
Хятад, Макао	136	172	167	6	0	3	187



Мадагаскар	7	8	6	0	2	6	13
Малави		2	1	0	0	3	5
Малайз	1672	1731	2062	53	71	1034	2235
Мальдив	17	10	32	4	5	11	12
Мали	0	5	4	0	1	1	2
Мальта	18	16	26	0	0	3	26
Мартиник				0	0		0
Мавритан		2	6	0	0		11
Маврики	15	30	15	0	4	9	8
Мексик	189	191	222	4	1	56	115
Монако	8	12	5	0	0	1	1
Молдав	39	46	62	17	13	34	20
Монтенегро	8	4	16	1	4	13	24
Монтсеррат				0	0		0
Марокко	18	30	35	2	13	23	35
Мозамбик			7	0	0	2	4
Оман	28	25	39	1	1	18	9
Намиби	4	1	4	0	3	2	4
Науру	3	4	3	0	0		0
Балба	221	331	396	7	12	67	252
Нидерланд	3099	3777	3613	86	63	792	1278
Курчао				0	0		0
Аруба				0	0		0
Сент Мартин (Герман)				0	0		0
Бониа, Синт-Эттатиус, Саба				0	0		0
Шинэ Каледони				0	0		0
Вануату	6	7	11	0	0	1	5
Шинэ Зеланд	986	1059	1250	57	28	162	466
Никарагуа	3	2		0	0		4
Нигер	5	10	7	0	0	1	1
Нигери	30	42	24	1	4	18	25
Ниуэ	1			0	0		0



Норфолк Арал				0	0		0
Норвеги	720	752	574	35	21	158	269
Хойд Марианын Арлууд				0	0		0
Минорын Арлын Нэгдсэн Улс				0	0		0
Микронез			3	0	0	2	0
Маршаллын Арлууд		5	2	0	0		0
Палау	8	3	4	0	0		0
Пакистан	234	292	315	6	136	147	216
Панам	3	5	9	3	0	4	7
Папуа Шинэ Гвиней	10	2	12	0	1	4	9
Парагвай	6	11	5	0	0		3
Перу	74	76	80	4	8	27	74
Филиппин	1219	1169	1204	79	54	468	1091
Питкern				0	0		0
Польш	1276	1196	1499	42	67	337	879
Португал	317	406	541	17	5	101	203
Гвиней Бисау	1			0	0		1
Тимор Лесте	12	7	11	0	0	2	1
Пуэрто Рико				0	0		0
Катар	228	418	864	11	118	107	575
Реюньон		1		0	0		0
Румын	306	304	370	21	25	123	300
Орос	106885	129095	141927	29635	12525	153162	212332
Руанда	2	2	1	0	0	2	4
Сент Бартелеми				0	0		0
Сент Елена				0	0		0
Сент Китс ба Невис	9	12	10	2	2	7	6
Ангилья				0	0		0



Сент Люси			2	0	1	1	1
Сент Мартин (Франц)				0	0		0
Сент Пьер ба Микелон	1	1		0	0	1	0
Сент Винсент ба Гренадин	1		1	0	0		0
Сан Марино	7	2		0	0		2
Сан Томе Принсипи				0	0		0
Саудын Араб	73	101	91	0	41	65	160
Сенегал	3	4	3	0	0	1	5
Серб	274	356	632	78	29	87	194
Сейшел	7	8	5	1	0	2	2
Сьерра Леоне	1	3		0	0	1	4
Сингапур	2485	2649	3010	65	29	753	2610
Словак	411	395	402	8	11	78	105
Вьетнам	947	704	1061	65	14	1309	1570
Словен	98	133	162	0	31	95	146
Сомали	1	5	6	0	0		3
Өмнөд Африк	445	481	495	64	45	289	432
Зимбабве	11	24	10	0	2	19	20
Испани	1647	1969	2080	48	35	419	1003
Өмнөд Судан	0	2	1	0	0	1	1
Судан	38	45	75	0	4	4	34
Баруун Сахар				0	0		0
Суринам			1	0	0		1
Шпицберген ба Ян-Майен				0	0		0
Свазиланд		1	1	0	0		4
Швед	1166	1154	1439	50	56	387	896
Швейцар	2767	2665	2927	76	66	686	1356
Сири	89	94	116	2	85	100	111



Тажикистан	43	59	138	12	5	35	92
Тайланд	1492	2259	2631	127	93	618	2004
Того	14	32	48	0	0	6	10
Токилау				0	0		0
Тонга	2	5	3	0	0		3
Тринидад Табаго	3	5	5	0	0	1	4
Эмират	186	214	209	6	57	77	124
Тунис	22	24	43	0	0	13	24
Турк	2189	2699	1874	545	1401	3453	6108
Туркменистан	13	44	75	1	7	49	51
Туркс ба Кайкос Арлууд				0	0		0
Тувалу		2		0	0		2
Уганда	22	36	76	1	0	4	14
Украйн	1309	1541	1233	190	374	210	256
Македони	25	23	34	3	4	14	27
Египет	50	53	65	2	24	41	87
Их Британи	5996	5905	5931	302	182	1578	3319
Гернси				0	0		0
Жерси				0	0		0
Мэн арал				0	0		0
Танзани	9	6	9	1	0	3	6
Америк	16667	17838	18838	1147	1570	8562	13539
Виржиний Арлууд (Америк)				0	0		0
Буркина Фасо	5	6	1	0	3	11	4
Уругвай	74	44	80	5	0	8	12
Узбекистан	129	118	244	16	44	529	902
Венесуел	37	23	132	7	0	3	15
Уоллис ба Футуна				0	0		0
Самоа	2	2	0	1	0		4
Йемен	47	32	55	0	5	38	50
Замби	10	11	13	2	1	8	18
Косово	3	4	13	0	3	11	23
Харьяалалгүй	31	32	35	2	1	11	6



Кот дИвуар	2	5	3	0	1	2	0
Солонгос /Хойд/	770	411	454	14	1	7	17

Эх сурвалж: YCX, 1212.mn

7

УЛСЫН ХИЛЭЭР ОРСОН ГАДААДЫН ЗОРЧИГЧДЫН ТОО (аяллын зорилго, бүс нутгаар,жилээр)

Статистик үзүүлэлт	Аяллын зорилго	2019	2020	2021	2022	2023
Бүгд	Бүгд	636960	66940	39236	300520	644064
Бүгд	Албан ажлаар	52680	19738	10935	27550	34620
Бүгд	Хувийн журмаар	207850	27996	18327	121936	198291
Бүгд	Жуулчлал	260078	7798	1010	122930	320630
Бүгд	Ажиллах	41392	5556	4491	6671	25874
Бүгд	Дамжин өнгөрөх	8758	317	68	5492	23588
Бүгд	Суралцах	6503	542	509	1677	9274
Бүгд	БОС	11765	1983	1136	5890	14903
Бүгд	Бусад	47934	3010	2760	8374	16884
Америк	Бүгд	27174	1862	2054	11086	17786
Америк	Албан ажлаар	2431	366	601	1353	1677
Америк	Хувийн журмаар	6699	610	883	3027	2993
Америк	Жуулчлал	14103	296	155	5200	11289
Америк	Ажиллах	1342	248	192	411	466
Америк	Дамжин өнгөрөх	167	5	4	45	281
Америк	Суралцах	83	17	18	86	73
Америк	БОС	804	193	96	463	838
Америк	Бусад	1545	127	105	501	169
Зүүн Ази болон Номхон далайн орнууд	Бүгд	390323	27806	12799	103374	350738
Зүүн Ази болон Номхон далайн орнууд	Албан ажлаар	31482	9195	6790	15091	23884

⁷ Үндэсний статистикийн хороо, 1212.mn



Зүүн Ази болон Номхон далайн орнууд	Хувийн журмаар	98608	6980	2169	26849	63509
Зүүн Ази болон Номхон далайн орнууд	Жуулчлал	166972	4083	515	50658	202609
Зүүн Ази болон Номхон далайн орнууд	Ажиллах	35859	3955	2196	3836	22052
Зүүн Ази болон Номхон далайн орнууд	Дамжин өнгөрөх	5286	154	16	1343	10175
Зүүн Ази болон Номхон далайн орнууд	Суралцах	5663	376	146	532	7497
Зүүн Ази болон Номхон далайн орнууд	БОС	6663	970	338	1980	7090
Зүүн Ази болон Номхон далайн орнууд	Бусад	39790	2093	629	3085	13922
Европ	Бүгд	205230	35931	21419	177833	260606
Европ	Албан ажлаар	15258	9626	2239	8430	5293
Европ	Хувийн журмаар	100286	20156	14527	90371	129971
Европ	Жуулчлал	74143	3331	290	65644	102730
Европ	Ажиллах	2594	1100	1636	1245	1261
Европ	Дамжин өнгөрөх	3221	138	48	3983	11262
Европ	Суралцах	727	145	336	1025	1655
Европ	БОС	3853	722	622	3020	6115
Европ	Бусад	5148	713	1721	4115	2319
Ойрхи Дорнод	Бүгд	5289	620	1917	4668	8741
Ойрхи Дорнод	Албан ажлаар	1855	398	1001	1886	2751
Ойрхи Дорнод	Хувийн журмаар	857	113	608	1098	968
Ойрхи Дорнод	Жуулчлал	1787	40	38	916	2280
Ойрхи Дорнод	Ажиллах	177	27	110	275	533
Ойрхи Дорнод	Дамжин өнгөрөх	52	19	0	113	1776
Ойрхи Дорнод	Суралцах	13	1	4	10	17



Ойрхи Дорнод	БОС	89	7	12	61	216
Ойрхи Дорнод	Бусад	459	15	144	309	200
Өмнөд Ази	Бүгд	6463	296	643	2157	4349
Өмнөд Ази	Албан ажлаар	1321	48	207	585	745
Өмнөд Ази	Хувийн журмаар	1092	89	94	394	594
Өмнөд Ази	Жуулчлал	2787	43	9	407	1398
Өмнөд Ази	Ажиллах	299	43	155	349	1061
Өмнөд Ази	Дамжин өнгөрөх	17	1	0	4	47
Өмнөд Ази	Суралцах	9	1	2	12	21
Өмнөд Ази	БОС	123	19	34	146	278
Өмнөд Ази	Бусад	815	52	142	260	205
Африк	Бүгд	2444	422	401	1391	1835
Африк	Албан ажлаар	329	105	97	205	270
Африк	Хувийн журмаар	291	47	46	189	254
Африк	Жуулчлал	284	5	3	103	321
Африк	Ажиллах	1121	183	202	555	501
Африк	Дамжин өнгөрөх	15	0	0	4	47
Африк	Суралцах	7	1	2	12	11
Африк	БОС	232	72	33	220	363
Африк	Бусад	165	9	18	103	68
Харьяалалгүй	Бүгд	37	3	3	11	9
Харьяалалгүй	Албан ажлаар	4	0	0		
Харьяалалгүй	Хувийн журмаар	17	1	0	8	2
Харьяалалгүй	Жуулчлал	2	0	0	2	3
Харьяалалгүй	Ажиллах	0	0	0		
Харьяалалгүй	Дамжин өнгөрөх	0	0	0		
Харьяалалгүй	Суралцах	1	1	1		
Харьяалалгүй	БОС	1	0	1		3
Харьяалалгүй	Бусад	12	1	1	1	1

Эх сурвалж: YCX, 1212.mn



“Дижитал номад хөтөлбөр”-ийг хэрэгжүүлснээр бий болох эдийн засгийн өсөлтийг урьдчилан таамаглахын тулд дижитал нүүдэлчдийн зардал, хөтөлбөрт хамрагдаж болох дижитал нүүдэлчдийн тоо зэргийг дараах байдлаар таамаглаж байна.

1.Дижитал нүүдэлчдийн сарын дундаж зардал: Дижитал нүүдэлчид ихэвчлэн байр, хоол, унаа, коворкинг, зугаа цэнгэлд мөнгө зарцуулдаг. Зарцуулсан хэмжээ нь байршлаас хамааран ихээхэн ялгаатай байж болох ч сард дунджаар 1,500 ам.доллар зарцуулна гэж үзье.

2.Дижитал нүүдэлчдийн тоо: Эхний ээлжинд жилд 1,000-5,000 дижитал нүүдэлчин ирнэ гэж таамаглаж болно. Энэхүү тооцоолол нь хөтөлбөрийн амжилттай хэрэгжих эсэхээс шалтгаалах бөгөөд жилд дунджаар 3000 дижитал нүүдэлчин ирнэ гэж таамаг дэвшүүлж байна.

3. Ажлын байр бий болгох: Дижитал нүүдэлчдийн үйлчилгээний эрэлт нь зочломтгой байдал, коворкинг, аялал жуулчлал, нийтийн үйлчилгээ зэрэг салбарт шинэ ажлын байр бий болгоход хүргэж болзошгүй юм. Таамаглалын хүрээнд хөтөлбөрийн үр дүнд 200 шинэ ажлын байр бий болж, нэг ажлын байрны сарын дундаж цалин 2 сая төгрөг байна гэж тооцож үзье.⁸

Эдийн засгийн өсөлтийн таамаглал:

Зүйл	Үнэлгээ	Тайлбар
Нэг дижитал номадын сарын дундаж зарлага	5,250,000 ₮	Номадын сар бүр зарцуулах дундаж мөнгө
1 жилд ирэх дижитал номадын тоо (дундажаар)	3,000 хүн	Хөтөлбөрт оролцохоор тооцоолсон дижитал номадын тоо
Нийт сарын зарлага (Бүх номад)	15,750,000,000₮	Бүх номадын сар бүрийн нийт зарлага (3,000 номад)

⁸ Үндэсний статистикийн хороо, 1212.mn



Нийт жилийн зарлага (Бүх номад)	189,000,000,000₮	Бүх номадын 12 сарын нийт зарлага
Оролцоо эффект (1.5)	1.5	Эдийн засгийн хоёрдогч нөлөөллийг харгалзан тооцсон коэффициент
Эдийн засгийн нөлөөлөл (Оролцоо эффектоор)	283,500,000,000 ₮	Зарлага болон оролцоо эффектын нийлбэр эдийн засгийн нөлөөлөл
Ажлын байрны бүтэц	200 ажлын байр	Шинээр үүсэх ажлын байрны тоо
Ажлын байрны дундаж цалин (MNT)	2,000,000₮	Шинээр үүсэх ажлын байрны дундаж жилийн цалин
Ажлын байрны үүсгэх орлого	400,000,000₮	Ажлын байрны үүсгэсэн нийт орлого
Нийт эдийн засгийн өсөлт	283,900,000,000₮	Зарлага, оролцоо эффект, ажлын байрны үүсгэсэн орлогыг хамарсан нийт эдийн засгийн өсөлт

Дижитал номад хөтөлбөрийн хэрэгжилтээр Монгол улсад 283.9 тэрбум төгрөгийн эдийн засгийн өсөлт үүсэх боломжтой гэсэн таамаглал бүхий тооцоог гаргасан. Энэ нь зарлага, оролцоо эффект, шинээр бий болсон ажлын байрнаас үүсгэх орлогыг хамарсан тооцоолол юм.



“ДИЖИТАЛ НОМАД ХӨТӨЛБӨР”-ИЙГ МОНГОЛ УЛСАД ХЭРЭГЖҮҮЛЭХ ТАЛААР ГАРГАСАН САНАЛ, ЗӨВЛӨМЖ, ДҮГНЭЛТ

Өвөрмөц газарзүй, шинээр хөгжиж буй дижитал дэд бүтэц, соёлын баялаг өвийг харгалзан үзвэл Монгол улс дижитал нүүдэлчдийн хүсэн хүлээж буй газар болох боломжтой.

“Дижитал номад хөтөлбөр”-ийг Монгол улсад хэрэгжүүлэх талаарх санал, зөвлөмж:

1. Хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх санал:

А. Дижитал дэд бүтцийг хөгжүүлэх:

Өндөр хурдны интернет: Дижитал номад хөтөлбөр амжилттай хэрэгжих эсэх нь найдвартай, хурдан интернетээс хамаардаг.

Б. Co-working Spaces & Community Hubs:

Улаанбаатар, Эрдэнэт, Дархан зэрэг томоохон хот суурин газрууд болон аялал жуулчлалын бүсүүдэд орчин үеийн тохилог хамтын оффис, коммюнити хабыг олноор байгуулах хэрэгтэй.

Эдгээр орон зай нь дижитал нүүдэлчдийг найдвартай интернет, хэвлэх, хурлын өрөө, тэр ч байтугай олон нийтийн эвент арга хэмжээ зэрэг зайлшгүй шаардлагатай хэрэгслээр хангана.

В. Виз ба хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх:

Дижитал нүүдэлчдэд зориулсан визтэй болох: Дижитал нүүдэлчдийг Монгол улсад удаан хугацаагаар ажиллаж, амьдрах эрх зүйн орчныг бүрдүүлж “Дижитал номад виз”-ийг (DNV) нэвтрүүлэх шаардлагатай.



Энэхүү виз нь мэдүүлгийн хялбаршуулсан журам, бусдаас зардал бага, хугацааг 1-2 жилээр сунгах боломжтой байх зэрэг давуу талуудыг санал болгох хэрэгтэй. Үүнийг хэрэгжүүлэхийн тулд Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль, Монгол улсын виз олгох журам, Гадаадын иргэн Монгол улсад оршин суух болон түүнийг бүртгэх журам зэрэгт тодорхой хэмжээний өөрчлөлт оруулах шаардлагатай.

Дижитал номад визний шалгуурт ихэвчлэн дараахь зүйлсийг оруулах боломжтой.

- Хамгийн бага орлогын хэмжээг тодорхойлж, баталгаажуулах;
- Гэмт хэрэг үйлдэж байгаагүй тухай бүртгэл, лавлагаа;
- Хөдөлмөр эрхлэлтийн баталгаа;
- Эрүүл мэндийн даатгалын баталгаа;

Г.Татварын урамшуулал:

Дижитал нүүдэлчдийн сонирхолыг татахын тулд тэдэнд татварын хөнгөлөлт үзүүлэх боломжтой. Ингэхийн тулд Монгол улсаас гадуур олсон орлогын татвараас чөлөөлөх боломжтой. Мөн Засгийн газрын 2023 оны 39 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Гарааны компани болон программ хангамжийн үйлдвэрлэл, хөгжүүлэлтийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжид дэмжлэг үзүүлэх журам”-тай уялдуулан дижитал нүүдэлчдийг монгол иргэдтэй хамтран гарааны бизнес эрхлэгчээр хамтын оффист бүртгүүлж дээрх журамд заасан хөнгөлөлтүүдийг эдлэх боломжийг бүрдүүлж болно.

Д. Олон нийтийн оролцоо ба эвент:

Дижитал нүүдэлчид иргэдтэй харилцах, Монголын түүх, хэл, соёлтой танилцах, хөгжлийн төслүүдэд хувь нэмрээ оруулах соёлын солилцооны арга хэмжээг зохион байгуулж болно.

Е. Тогтвортой аялал жуулчлал:



Дижитал нүүдэлчдийг Монгол орны газар нутгийг судлах, хөдөөгийн аялал жуулчлалд хувь нэмрээ оруулах, орон нутгийн эдийн засгийг идэвхжүүлэхийг дэмжих боломжтой. Удаан хугацаагаар аялдаг дижитал нүүдэлчид нь аялал жуулчлалын аялалын үргэлжлэх хугацааг уртасгаж, хот суурин газрын дарамтыг бууруулж, эдийн засгийн үр өгөөжийг түгээхэд тусалдаг.

Ё.Бизнесүүдтэй хамтран ажиллах:

Зочид буудал, зоогийн газар, тээврийн үйлчилгээ зэрэг бизнес эрхлэгчидтэй хамтын ажиллагаа тогтоож дижитал нүүдэлчдэд ээлтэй багцуудыг бий болгоно. Жишээлбэл, бизнесүүд удаан хугацаагаар оршин суух эсвэл ажлын байр түрээслэдэг дижитал нүүдэлчдэд хөнгөлөлттэй үнэ санал болгож болно.



2. УРТ ХУГАЦААНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗӨВЛӨМЖ:


А. Маркетинг, сурталчилгаа хийх:

Дэлхий даяарх дижитал нүүдэлчдийг татах зорилтот түвшинг тодорхойлж тэднийг татах:

Монгол улс өөрийгөө дижитал нүүдэлчдийн хувьд өвөрмөц, соёлын баялаг газар болгон зах зээлд гаргах ёстой. Монгол орны боломжийн үнэ, баялаг түүх, үзэсгэлэнт газар нутаг зэргийг сурталчилж, тэднийг татах хэрэгтэй.

Олон улсын дижитал нүүдэлчдийн холбоотой хамтран ажиллах: Монголын дижитал нүүдэлчдийн визийг сурталчлах, дижитал нүүдэлчдийг Монголыг ажиллангаа аялахад тохиромжтой байхыг дэмжих зорилгоор Nomad List, Remote Year, Coworker зэрэг нүүдэлчдийн нийгэмлэг, платформуудтай хамтран ажиллах нь зүйтэй.

Тухайлбал: Nomad.com цахим хуудсанд Mongolia гэж хайхад дараах үр дүнг харуулж байна.



Эндээс манай улсыг эрүүл мэндийн үйлчилгээнээс бусдыг нь сайнаар үнэлсэн байгааг харж болно.

9

^{9 9} Эх сурвалж: <https://nomads.com/>



Б. Төр, хувийн хэвшлийн түншлэлийг эрчимжүүлэх:

Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа: Монголын улсад дижитал нүүдэлчдийн экосистемийг бий болгохын тулд хувийн компаниуд, томоохон эрүүл мэндийн байгууллагууд, аялал жуулчлалын зөвлөлүүд, технологийн гарааны компаниудтай нягт хамтран ажиллах нь зүйтэй. Үүнд:

- дижитал нүүдэлчидтэй холбоотой дэд бүтцийн санхүүжилт, хамтран ажиллах орон зайд татварын хөнгөлөлт үзүүлэх;
- хувийн хэвшлийн томоохон эмнэлэгүүдтэй хамтран дижитал номадуудад зориулсан эрүүл мэндийн үйлчилгээний тогтолцоог сайжруулах;
- олон нийтэд сурталчлах.

В. Тасралтгүй сайжруулалт хийх:

Хөтөлбөрийн үр нөлөөг хянах нь маш чухал юм. Дижитал нүүдлийн виз нь алсаас ажиллагсад болон хүлээн авагч орнуудад харилцан ашигтай боломжийг олгодог. Тэд номадуудад эдийн засгийг дэмжихийн зэрэгцээ шинэ соёлыг мэдрэх боломжийг санал болгодог. Гэсэн хэдий ч амжилттай виз авагчийн дагаж мөрдөх шаардлага, дүрэм журмын хэрэгжилтийг хангаж байгаа эсэхэд хяналт тавих нь чухал.

ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛСНЭЭР БИЙ БОЛОХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ЗӨВЛӨМЖ

Дижитал номад хөтөлбөрийн үр өгөөжийг нэмэгдүүлэх, тулгамдаж буй бэрхшээлийг шийдвэрлэхийн тулд тус хөтөлбөрийг хэрэгжүүлэгч орнууд дараах зүйлд анхаарлаа хандуулах хэрэгтэй. Үүд:

- Дижитал номадууд эдийн засагт хувь нэмрээ оруулахын тулд татварын зөв зохистой бодлогыг хэрэгжүүлэх;



- Иргэдийг нүүлгэн шилжүүлэхээс сэргийлж хямд үнэтэй орон сууцны бодлогыг хэрэгжүүлэх;
- Байгаль орчны сөрөг нөлөөллийг багасгахын тулд тогтвортой аялал жуулчлалд хөрөнгө оруулах;
- Соёлын солилцоог дэмжих, орон нутгийн иргэд болон дижитал нүүдэлчдийн хоорондын хурцадмал байдлыг бууруулах арга хэмжээг дэмжих.

ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛСНЭЭР БИЙ БОЛОХ

ҮР ДҮН

Монгол улс дижитал номад хөтөлбөрийг хэрэгжүүлснээр эдийн засгийн өсөлт, соёлын солилцоо, аялал жуулчлал, нийтийн үйлчилгээг дэмжих зэрэг олон эерэг үр дүнг авчрах болно.

Хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэхийн тулд төр, хувийн хэвшил, бизнесийн байгууллагууд хамтран ажиллах нь зүйтэй.

Хууль эрх зүйн орчин бүрдүүлэх, дэд бүтцийн хөгжлийг сайжруулах, соёлын солилцооны үйл ажиллагааг хэрэгжүүлэхийг төрийн зүгээс дэмжих нь хөтөлбөрийн урт хугацааны амжилтын үндэс байх болно.

Энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлснээр дэлхийд танигдсан дижитал номад хүлээн авдаг орон болох боломжтойгоос гадна Монгол улсыг алсаас ажиллагсадын олон улсын төв болгох боломжтой.



АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ, МАТЕРИАЛ

1. Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль, 2010 он
2. Гадаадын иргэн монгол улсад оршин суух болон түүнийг бүртгэх журам,
Засгийн газрын 2021 оны 194 дүгээр тогтоолын хавсралт
3. Үндэсний статистикийн хороо, 1212.mn
4. <https://www.mbopartners.com>
5. [visaguide.world](https://www.visaguide.world)
6. [Nomad.com](https://www.nomad.com)

